



ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2014 оны 01 дугаар
сарын 13-ны өдөр

№ 05

Улаанбаатар хот

Хөдөлмөр эрхлэлтийн хөтөлбөр, төслүүд батлах тухай

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 28.8.2-т заасныг үндэслэн Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. “Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр”-ийг нэгдүгээр, “40-өөс дээш насны иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийг хоёрдугаар, “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийг гуравдугаар, “Аж ахуй эрхлэлтийг хөгжүүлэх хөтөлбөр”-ийг дөрөвдүгээр, “Эзэнтэй Монгол хөтөлбөр”-ийг тавдугаар, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийг зургадугаар хавсралтаар тус тус нэмэлт өөрчлөлт оруулж баталсугай.

2. “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийг долдугаар, “Үндэсний мэргэжилтэй ажилтан бэлтгэх хөтөлбөр”-ийг наймдугаар, “Оюутны хөдөлмөр эрхлэлт ба цагийн ажил” хөтөлбөр”-ийг есдүгээр, “Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ” төслийг аравдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

3. Хөдөлмөр эрхлэлтийн хөтөлбөр, төслүүдэд шаардагдах зардлыг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн батлагдсан төсвийн хуваарьт багтаан санхүүжүүлэхийг Хөдөлмөрийн яамны Санхүү, сангийн бодлого төлөвлөлтийн газар /С.Наранцогт/-т даалгасугай.

Үндэсний зөвлөлийн дарга,
сайд



Я.САНЖМЯТАВ

Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн
дарга

Д.ХАДХҮҮ